HAPPY LEARNING ACADEMY

SUMMER - WINTER

# HLA CAMP

**A FUN FILLED EXPERIENCE WITH OUR CAMP**




**SCAN ME**

**FOR MORE INFOR**







HLA.asia.cebu

www.hla.asia

(+63) 977 755 7559
(+63) 32 429 1237

Camino Vicinal Road, TabokTulay, Cotcot, Liloan ,Cebu, Philippines

# АГУУЛГА


| | |
|---|---|
| ТАНИЛЦУУЛГА- HLA БУЮУ БИДНИЙ ТУХАЙ | 01 - 02 |
| ЯАГААД HLA-Г СОНГОХ ХЭРЭГТЭЙ ВЭ? | 03 - 04 |
| HLA-Н СУРГАЛТЫН ХӨТӨЛБӨР | 05 - 06 |
| HLA-Н ҮНЭЛГЭЭ - ТҮВШИНГИЙН ГОЛ АГУУЛГА | 07 - 08 |
| АНГИЙН БҮТЭЦ - ЕРӨНХИЙ ХУВААРЬ | 09 - 10 |
| IELTS КЭМП - IELTS-ИЙН ХУВААРЬ | 11 - 12 |
| ДОЛОО ХОНОГИЙН ХУВААРЬ - САРЫН ХУВААРЬ | 13 - 14 |
| АМРАЛТЫН ӨДРИЙН ҮЙЛ АЖИЛЛАГАА - ОЮУТАНАА АНХААРАХ, ДЭМЖИХ | 15 - 16 |
| WELCOME PARTY - АНГЛИ ХЭЛНИЙ ТОГЛООМЫН ӨДӨР | 17 - 18 |
| ROLLING PAPER – ДҮНГИЙН ХУУДАС | 19 - 20 |
| ТӨГСӨЛТИЙН БАЯР | 21 - 22 |
| ЭЛСЭЛТИЙН МЭДЭЭЛЭЛ | 23 |
| ӨРГӨДЛИЙН МЭДЭЭЛЭЛ - ХӨТӨЛБӨР ЦУЦЛАХ БОЛОН ТӨЛБӨРИЙН БУЦААН ОЛГОЛТ | 24 |
| ОЮУТНЫ УДИРДАМЖ | 25 |
| ХОХИРЛЫГ НӨХӨН ТӨЛҮҮЛЭХ | 26 |
| ОЮУТНЫ КЭМПИЙН БОДЛОГО | 27 - 28 |
| HLA-Н БОДИТ ЗУРАГ | 29 - 32 |
| HLA-Н ДЭД БҮТЭЦ | 33 - 36 |

# УДИРТГАЛ

Хүүхэд бүрийн гаргасан амжилт, инээмсэглэлийн тоогоор ололт амжилтууд маань хэмжигддэг HLA-ийн Зуны зуслан тавтай морилно уу.

HLA-ийн Зуны зуслан 2025 хөтөлбөрийн зорилго нь энгийн боловч гүн гүнзгий утга агуулгатай юм. Бидний гол зорилго 6-16 насны хүүхдүүдэд англи хэл сурахаас гадна хөгжиж, нөхөрлөлийг бий болгож, зуслангийн баяр баясгалантай, аюулгүй, эрүүл, тав тухтай орчныг бүрдүүлэхэд оршиж байна.

Филиппинд англи хэл сурах нь англи хэлээр ярьдаг гадаад оронд суралцах онцгой бөгөөд гайхалтай өндөр үр дүнтэй арга юм. Мэргэжлийн өндөр ур чадвартай багш нартай, төрөл бүрийн англи хэлний хөтөлбөрүүдтэй, онцлог содон соёлтой тул хэл сурахад хамгийн тохиромжтой газар болж өгдөг. Мөн хичээлээс гадна хүүхдүүд Филиппин улсын баялаг их түүх, соёл, байгалийн үзэсгэлэнт газруудтай танилцах боломжтой. Та хүүхдийнхээ англи хэлний академик ерөнхий мэдлэг, харилцааны ур чадвар, хувь хүний хөгжил зэрэг чадваруудаас алийг нь ч нэмэгдүүлэх хүсэлтэй байсан, Филиппинд байрлах HLA-ийн Зуны зуслан 2024 нь хүүхэд бүрд эерэг өөрчлөлт, мартагдашгүй дурсамжийг амлаж байна.

## Happy Learning Academy-н VMGO /Алсын хараа эрхэм зорилго, зорилтууд/

Happy Learning Academy-ийн эрхэм зорилго нь төрөлх англи хэлээр ярьдаггүй орнуудын суралцагч нарт тохирсон онцгой хэлний хөтөлбөрөөр дамжуулан өөрсдийн мэдлэг чадварыг бүрэн хэрэгжүүлэн харилцаа холбоо, соёлын ойлголтыг таниулахад нь тусалж тэднийг бүрэн чадамждаа хүрэхэд дэмжихэд оршино.

Happy Learning Academy нь суралцагчдадаа харилцааны ур чадвараа хөгжүүлэх, академик болон мэргэжлийн англи хэлээ суралцаж сайжруулахад нь дэмжлэг үзүүлэх, өөр өөр соёлтой хүмүүстэй нэгдэхэд нь туслах чанартай, хүртээмжтэй, хувь хүний онцлогт тохирсон англи хэлний сургалтыг хүргэхэд оршино.

Зорилт: Happy Learning Академи нь төрөлх англи хэлээр ярьдаггүй суралцагчдад  мэргэжлийн болон нийгмийн салбарт амжилт гаргах ур чадвар, өөртөө итгэх итгэлийг олгох англи хэлний үлгэр жишээ боловсролыг хүргэж, соёлын баялаг болон хувь хүний өсөлт хөгжилтэй орчинг бүрдүүлэхэд анхаардаг.

Happy Learning Academy-зорилго нь хувь хүний хэрэгцээнд тохирсон сургалтын төлөвлөгөөг гарган, тогтмол явцын үнэлгээг хийж  чиглэсэн хэлний ур чадваруудын сургалтыг хэрэгжүүлэх замаар нэг хичээлийн улиралд суралцагчдын англи хэлний мэдлэгийн түвшинг нэмэгдүүлэх явдал юм



## 1. БАЙРШИЛ

Happy Learning Academy - HLA нь Филиппиний Себу хотын тааламжтай бүсэд байрладаг ба тус арал нь Өмнөдийн хатан хаан гэдгээрээ алдартай. Себу арал бол Филиппин улсын хамгийн үзэсгэлэнтэй, аюулгүй, аялал жуулчлалын бүс ба Англи хэлээр ярьдаг гуравдагч том улс болох Филиппинд суралцах нь тус улсын байгалийн үзэсгэлэнт, аялал жуулчлалын газруудтай танилцах боломжийг олгодог. HLA нь Себу хотын төвөөс 16 км зайд; нисэх онгоцны буудлаас 9 км зайд; Олон улсын эмнэлгээс 7 км, SM Consolacion дэлгүүрээс 7 км зайд байрладаг.

## 2. БОЛОВСРОЛ

Happy Learning Academy нь Кембрижийн сургалтын хөтөлбөрийн дагуу, дэлхийн томоохон боловсролын байгууллагуудад өргөн хэрэглэгддэг, хүлээн зөвшөөрөгдсөн Common European Framework of Reference for Languages (CEFR)-г үндэслэн суралцагчдын ур чадварыг үнэлдэг. Элсэлтийн шалгалтаар сурагч тус бүрийн ур чадвар, түвшинг тодорхойлон түүнд тохирсон ангид хувиарлагдсанаар багш нар сурагч бүрийн давуу тал, хөгжүүлэх шаардлагатай чадваруудыг танин тухайн сурагчид тохирсон хичээлийн хөтөлбөр зохиодог нь өөртөө итгэлтэйгээр англи хэлний мэдлэгээ тасралтгүй ахиулах боломжийг олгодог.

## 3. БАЙГУУЛАМЖ

Филиппин улсын Себу хотод нийт 12,000м$^2$ талбайтай Happy Learning Academy нь бага насны сурагчдад суралцах, тоглоход нэн тохиромжтой газар юм.
HLA нь 88 - /1:1/ буюу ганцаарчилсан хичээлийн анги, 19 групп хичээлийн танхимтай бөгөөд анги бүр хичээллэхэд шаардлагатай тоног төхөөрөмж, хэрэгслээр бүрэн тоноглогдсон. Түүнчлэн HLA нь хичээлийн ачаалалтай, урт өдрийн дараа сурагчдын бие бялдрын хөгжил, чийрэгжилтийг сайжруулж, стресс бууруулах хөгжөөнт тоглоом тоглож, амралт чөлөөт цагаа уйдахгүй өнгөрөөх боломцоогоор хангадаг.
Үүнд: усан сан, хөл бөмбөгийн талбай, сагсан бөмбөгийн талбай, мини-гольф, гүйлтийн талбай, унадаг дугуйн зам, ширээний теннис, бадминтон, биллиард зэрэг багтана.

# HLA-ийн ТУХАЙ



# ЯАГААД ӨВЛИЙН ЗУСАНГААР HLA-г СОНГОХ ВЭ?

**Яагаад HLA-ийн зусланд хамрагдах ёстой 10 шалтгааныг хүргэж байна.**

## 01 Мэргэшсэн заах арга зүй

Happy Learning Academy нь англи хэлийг хоёр дахь хэл болгон заах чиглэлээр мэргэшсэн, өндөр ур чадвартай, туршлагатай англи хэлний багш нараараа бахархдаг. Мөн Кэмбрижийн сургалтын хөтөлбөрийн дагуу Их Британийн профессоруудаар мэргэшин бэлтгэгдсэн HLA-ийн багш нар сургалтын төрөл бүрийн хэв маяг, хүүхэд бүрийн түвшинд тохирсон шинэлэг интерактив хичээлүүдийг бэлтгэж, суралцагчдад чанартай боловсрол олгоход анхаардаг.

## 02 Сонирхолтой, шинэлэг сургалтын хөтөлбөр

HLA-ийн Зуслан нь хэл сурахыг хөгжилтэй үйл ажиллагаа, арга хэмжээтэй хослуулсан динамик, шинэлэг сургалтын хөтөлбөртэйгөөрөө онцлог юм. Хүүхдүүд хичээлээс гадна тэмцээн уралдаанд оролцох, тоглоом тоглох, дүрд хувирах, сайн дурын үйл ажиллагаанд оролцох, олон орны соёлтой танилцах нь суралцах үйл явцыг сонирхолтой, үр дүнтэй болгодог. Үүнээс гадна суралцагчид бие бялдар болон сэтгэл санааг дэмжихэд туслах спортын болон хөгжмийн хичээлүүдэд хамрагддаг.

## 03 Сургалт

HLA нь хувь хүний анхаарал, идэвх оролцоог нэмэгдүүлэх үүднээс бүлгээр хичээллэх ангиуд, ялангуяа ганцаарчилсан сургалтыг түлхүү дэмждэг. Хичээл тус бүрд цөөн хүүхэд хамрагддаг тул багш нар хувь хүний зорилго шаардлагад анхаарлаа хандуулж, хүүхэд тус бүрд дэмжлэг үзүүлж, сурагчдад өөрсдийн хурдаар суралцах боломжийг олгодог.
Нэмж дурдахад HLA нь сурагч хоорондын харилцааг сайжруулахын тулд багийн үйл ажиллагаа, хөгжмийн хичээл, спортын арга хэмжээнүүдийг тогтмол зохион байгуулж, сурагчдыг нээлттэй өөртөө итгэлтэй болоход нь тусалдаг.

## 04 Шим тэжээлтэй хоол

HLA нь суралцагчдын эрүүл мэндийг дэмжихэд шаардлагатай витамин, шим тэжээл, эслэг, эрдэс бодис агуулсан шинэхэн хоолоор үйлчилдэг. Сурагчид өдөр бүр Вьетнам, Хятад, Монгол, Солонгос, Араб, Филиппин зэрэг үндэсний хоолыг багтаасан цэсээр гурван удаа хооллодог ба тэдгээр нь үе үе шинэчлэгдэж, түлхүү жимс болон сүү агуулсан байдаг. Мөн сургуулиас олон өдрийн хичээл, сургуулийн дараа сурагчдадаа шаардлагатай эрч хүч өгөхийн тулд нэмэлтээр пицца, шпагетти, чихэр, bubble tea зэрэг олон төрлийн амттан бэлтгэдэг.

## 05 Соёлын гайхалтай туршлага

HLA-ийн зуслан нь хүүхдүүдийг Филиппин улсын баялаг өв соёлтой танилцуулах соёлын арга хэмжээ, аяллыг зохион байгуулдаг. Зуслангийн амраг хүүхдүүд аялал жуулчлалын газрууд, түүхэн дурсгалт газрууд, нутгийн хүмүүстэй танилцаж, уламжлалт баяр наадамд оролцох боломжтой бөгөөд энэ нь орон нутгийн амьдралын хэв маягийг шимтэн үзэх, улс орны талаарх ойлголтоо нэмэгдүүлэх боломжийг олгодог нь гайхалтай дурсамж болон үлддэг.

## 06 Хамгийн сүүлийн үеийн барилга байгууламжууд

Happy Learning Academy нь мультимедиа ангиудаас эхлээд амралтын өрөө, усан сан, стандарт сагсан бөмбөгийн талбай, ширээний теннис, биллиард, дартс, шатар, дугуй унах гэх зэрэг сургалтын үр дүнг сайжруулах орчин үеийн, шинэлэг тоног төхөөрөмжөөр бүрэн тоноглогдсон байдаг.
Суралцагчдад англи хэлний дадлага өдөр тутамдаа хийж, ярих ур чадварыг нэмэгдүүлэхээс гадна бие бялдрын хөгжилд тусалдаг.

## 07 Аюулгүй тайван, олон улсын орчин

HLA нь суралцагчдын аюулгүй байдалд онцгой анхаарал хандуулдаг.
HLA-ийн Зуслан нь сурагчид өөртөө итгэлтэйгээр сурч, хөгжих боломжтой аюулгүй, тайван, анхаарал халамжаар дүүрэн орчин бүрдүүлдэг.
HLA-ийн бэлтгэгдсэн ажилтнууд 24 цагийн турш сурагчдад туслах, дэмжих зорилгоор бэлэн байдаг.
HLA-ийн Зуны зуслан 2024 нь Монгол, Тайвань, Япон, Хятад, Оман, Араб гэх мэт олон үндэстний сурагчтай. Энэ нь суралцагчид өдөр тутамдаа англи хэлийг ашиглаж, харилцах чадвараа сайжруулах хамгийн тохиромжтой орчинг бүрдүүлж өгдөг байна.

## 08 Боломжийн үнэ

Сингапур, Канад, Их Британи, АНУ гэх мэт орны англи хэлний зуны зуслангийн хөтөлбөрүүдтэй харьцуулахад HLA-ийн сургалтын төлбөр илүү боломжийн үнэтэй ба бусад орны сургалтын төлбөрөөс 3 дахин хямд байдаг ч илүү урт хугацааны хөтөлбөртэй байдаг. Мөн ганцаарчилсан анги, бүлгийн хичээл нь илүү чанартайгаас гадна амралтын өдрүүдээр аялаж Филиппиний соёл, хоол, байгалийн үзэсгэлэнт газруудтай танилцах боломжтойгоороо давуу талтай юм. Харин манай хөтөлбөрийн төлбөр нь Филиппин дэх зуны зуслангийн хөтөлбөрүүдээс өндөр байдаг нь HLA нь эцэг эхчүүд бидэнд итгэх итгэл, санаа амар байхад нь анхаарч сурагчдийн аюулгүй байдал, мэргэжлийн сургалтын орчин, өндөр чанартай сургалтаар хангах үүрэгтэйд оршино.

## 09 Сайжруулсан сургалтын хөтөлбөр:

HLA нь үндсэн хэлний сургалтаас гадна сайжруулсан сургалтын хөтөлбөрийг санал болгодог бөгөөд энэ нь ахисан түвшний сэдэв, практик хэрэглээ, таны зорилгод нийцсэн тусгайлсан хичээлүүдийг багтаасан хөтөлбөр юм. Үүнд нарийвчилсан дүрмийн сургалт, харилцан ярианы дадлага, стандартчилсан шалгалтанд бэлтгэх сургалт зэрэг орно. Сайжруулсан сургалтын хөтөлбөр нь суралцагчидын сурах үйл ажиллагааг цогц байдлаар хөгжүүлж, тэдний онцлог хэрэгцээ шаардлагад нийцүүлэхэд чиглэдэг.

## 10 Эерэг үнэлгээ ба амжилттай үр дүн:

HLA-ийн эерэг үнэлгээ нь өмнөх болон одоогийн суралцагчидын туршлагын талаарх ойлголт өгч, сургалтын чанар, дэд бүтэц, ерөнхий сэтгэл ханамж зэргийг нэгтгэн сургуулийн давуу талыг илтгэнэ. Сургуулийн төгсөлтийн хувь өндөр, хэлний мэдлэг сайжирсан эсвэл суралцагчид (стандартчилсан шалгалтуудад тэнцэх ) зэрэг амжилттай зорилгодоо хүрсэн байдал нь сургуулийн хөтөлбөрийн үр нөлөө, олгосон боловсролын үнэ цэнийг илэрхийлдэг.



# ЕРӨНХИЙ ХӨТӨЛБӨР

HLA Camp-д хамрагдаж буй суралцагсад  9 цагийн хичээлд хамрагдана. Үүнд 4цаг - 1: 1 буюу ганцаарчилсан анги, 3 цаг бүлгийн анги 1 цаг спортын хичээл /сонголтоор1 цаг хөгжим/ 1 цаг Мультимедиа англи хэлний хичээл/, Илтгэлийн сургалт 1 цаг болон Эссэ бичих 1 цагийн хичээл багтана. Энэ бүхнийг багшийн хяналтан дор зохион байгуулна. Өдөр бүр 8 цаг гаруй англиар ярьдаг орчин нь суралцагчдад англи хэлний хэрэглээгээ нэмэгдүүлж илүү хурдан сайжрах дадлыг бий болгож, англиар сэтгэн бодоход тусалдаг.  Ялангуяа HLA нь суралцагчид англи хэлээр ярих айдсаа давж, суралцах явцад үргэлж хүсэл эрмэлзэлтэй байлгахыг зорьдог.



Happy Learning Academy нь хүүхдийг амжилттай суралцахад эрүүл саруул бие бялдар чухал үүрэг гүйцэтгэдэг гэж үздэг. Иймд HLA-д Зумба, сагсан бөмбөг, усан сэлэлт, бадминтон, байт харваа, ширээний теннис, волейбол гэх мэт төрөл бүрийн биеийн тамирын дасгалуудыг санал болгож тэмцээн, уралдаан зохион байгуулдаг.

Мөн хүүхдүүдийн хичээлийн өдрийн оройн хуваарьт өдрийн тэмдэглэл бичих, эссэ бичих, илтгэл тавих зэрэг ур чадварыг сайжруулах даалгавар өгдөг нь тухайн хүүхдийг өөртөө итгэлтэйгээр англиар ярихад тусалдаг.

Харин амралтын өдрүүдэд аялал, спортын тэмцээн уралдаан, үндэсний уламжлалт тоглоом тоглоом тоглох зэргээр хүүхдийг илүү хөдөлгөөнтэй байхад анхаардаг.



# САЙЖРУУЛСАН ЕРӨНХИЙ ХӨТӨЛБӨР

Happy Learning Academy-ийн ESL CAMP-ийн суралцагчдад зориулсан сайжруулсан ерөнхий сургалтын хөтөлбөр нь англи хэлний мэдлэгийг янз бүрийн нөхцөл байдалд сайтар үнэлэхэд чиглэсэн. Үүнд: Сонсож ойлгох чадвар, Ярих чадвар, Уншиж ойлгох чадвар, Бичих чадвар гэсэн дөрвөн үндсэн бүрэлдэхүүн хэсэгтэй.

Сонсож ойлгох чадварын хэсэгт суралцагчид харилцан яриа, мэдээ мэдээлэл зэрэг төрөл бүрийн аудио материалыг сонсож, үндсэн санаа, тодорхой дэлгэрэнгүй мэдээллийн талаарх ойлголтыг шалгах асуултуудад хариулдаг. Ярианы ур чадварын хэсэг нь суралцагчид нэг нэгээрээ ярилцлага хийх бичлэг хийх даалгавар гүйцэтгэн асуултуудад хариулах зэрэг харилцааны ур чадвараа харуулахын тулд зураг тайлбарлах үгсийн харилцааны ур чадвараа харуулахад чиглэгдэнэ.

Уншиж ойлгох хэсэг нь оюутнуудын гол санаа, дэлгэрэнгүй мэдээлэл, дүгнэлтэнд чиглэсэн олон сонголттой, богино хариулттай асуултуудын тусламжтайгаар бичсэн текстийг тайлбарлах чадварыг үнэлдэг. Бичгийн ур чадвар гэдэг нь суралцагч тодорхой, уялдаатай текст бичих чадвараа харуулахын тулд хүүрнэх, дүрслэн тайлбарлан бичих зэрэг бүрэн даалгавруудыг гүйцэтгэдэг.

Үнэлгээ нь нарийвчилсан үнэлгээний загварын дагуу үнэн зөв, ур чадвар, хэлний тохиромжтой байдлыг үнэлдэг бөгөөд үүнд тулгуурлан хэлийг сайжруулахад чиглүүлэх зөвлөмж бүхий санал хүсэлтийг өгдөг. Бэлтгэлийн нөөцөд бүх оюутнуудад хүртээмжтэй байх үүднээс байр, жишээ тест болон дадлагын материалууд бэлэн байдаг. Энэхүү шалгалт нь ESL-ийн суралцагчид сурлагын болон өдөр тутмын амжилтанд шаардлагатай хэлний ур чадвартай байхыг хангахад чиглэнэ.



# HLA
# ҮНЭЛГЭЭ

HLA таны шалгалтанд бэлтгэх гарын авлагыг бэлэн болголоо.  Бидний цогц арга барил нь таны суралцаж буй үе шат бүрт сайтар бэлдэх боломжийг олгодог.. Бид таныг шалгалтын төрөл бүрээр хэрхэн сайтар бэлдэхийг эндээс танилцаарай.

## Элсэлтийн шалгалт

Амжилтанд хүрэх таны эхний алхам.  Академик аялалаа өөртөө итгэлтэйгээр эхлүүлээрэй. Манай элсэлтийн шалгалтын бэлтгэл нь таныг суурь ур чадвар, стратегид төвлөрч амжилт үзүүлэхэд нь туслахад чиглэгддэг. Шалгалтын форматыг ойлгож, үндсэн ойлголтуудыг давтаж, анхны сэтгэгдлийг сайжруулахад шаардлагатай өөртөө итгэх итгэлийг бий болгоно.



## Үгийн шалгалт

Үгийн сангийн шалгалт нь тухайн үгийн утга, хэрэглээний талаарх суралцагчийн ойлголтыг үнэлэх явдал юм. Энэ нь хэлний чадварын давуу болон сул талуудыг тодорхойлоход чиглэж суралцагцийг дэмжинэ. мөн энэ шалгалт нь суралцагчдыг үгийн сангаа тэлэхэд түлхэц өгөх замаар хэлээ сайжруулахад нэмэр болж чадна.

## Явцын шалгалт

Явцын шалгалтаар өөрийн өсөлтөө хэмжинэ. Эдгээр үнэлгээ нь таны сурлагын академик хөгжил болон бэлэн байдлыг үнэлэхэд хэрэгтэй мэдээллийг өгдөг. Давуу болон цаашид анхаарах шаардлагатай талуудыг ойлгох зорилгоор гүйцэтгэлийн нарийвчилсан тайлангуудыг хянаж зорилгодоо хүрэх зөв зам дээр байгаа эсэхээ шалгаарай.

## Бэлтгэлийн шалгалт

Бидний бэлтгэлийн шалгалтуудаар жинхэнэ тестийн орчныг мэдрээрэй. Эдгээр бэлтгэл шалгалтууд нь бодит шалгалтын хэлбэр, цагийн хуваарийг дуурайж, шалгалт өгөх стратегиа сайжруулах, сэтгэлийн түгшүүрийг бууруулах үнэ цэнэтэй боломжийг санал болгодог. Юу хүлээж байгаа талаар тодорхой дүр зургийг олж аваад бэлтгэлээ тохируулаарай.

## Долоо хоног тутмын шалгалт

Тогтмол үйл явц нь урт хугацааны амжилтын түлхүүр юм. Манай долоо хоног тутмын тестүүд нь суралцах чадвараа бататгах, таны ойлголтыг хянах, сайжруулах шаардлагатай хэсгийг тодорхойлох зорилготой юм. Тогтмол санал хүсэлт болон чиглэсэн дэмжлэг нь танд хичээлээ ахиулж, сорилт бэрхшээлийг нэн даруй шийдвэрлэхэд тусална.

## Эцсийн шалгалт

Таныг курсээ төгсөх дөхөх үед авагдах эцсийн шалгалтууд нь таны мэдлэг, ур чадварыг нэгтгэх зорилготой юм.Эдгээр шалгалтууд нь  таныг эцсийн үнэлгээнд бэлэн байх, сургалтын төгсгөлдөө сайн бэлтгэгдсэн эсэхдээ дүн шинжилгээ хийхэд тусална.

# ХЭЛНИЙ ТҮВШНИЙ ХУРААНГУЙ

| CEFR түвшин | Тодорхо йлолт | IELTS нийт оноо | TOEIC оноо | TOEFL iBT оноо | Түгээмэл Ерөнхий Англи Хэлний хичээлийн номын тодорхойлолт (Их Британи) | Кембрижийн номны тодорхойлолт |
|---|---|---|---|---|---|---|
| C2 | Мэргэшсэн | 8.5–9 | | 118-120 | Мэргэшсэн | |
| C1 | Гүнзгий шат | 7-8 | 945 -990 | 110-117 | Гүнзгий шат | |
| B2+ | Ахисан дунд | 5.5–6.5 | 785 -935 | 87-109 | Ахисан дунд (номны хоёрдугаар хагас) | |
| B2 | | | | | Ахисан дунд (номны эхний хагас) | |
| B1+ | Дунд | 4-5 | 550 -775 | 57-86 | Дунд (номын хоёрдугаар хагас) | Сургуульд зориулсан урьдчилсан сургалт (PET-ийн өмнө) |
| B1 | | | | | Дунд (номын эхний хагас) Анхан дунд (зарим хэвлэн нийтлэгчид) | |
| A2+ | Анхан дунд | 3–3.5 | 225 –540 | 32-56 | Анхан дунд (Бүх сэдвүүд) | Сургуульд зориулсан хуулбар 6 түлхүүр (KET-өмнө) |
| A2 | | 2–2.5 | | | Анхан шат (Бүх сэдвүүд) | Сургуульд зориулсан хуулбар түлхүүр |
| A1+ | Анхан шат | 1.5–2 | 120 -215 | 19-31 | Суурьгүй анхан (төгсгөлийн сэдвүүд) Анхан шат (эхний сэдвүүд) | Эхэн үе 4 |
| A1 | Суурьгүй анхан шат | 1 | | | Анхан шат (дундаас төгсгөлийн сэдэв хүртэл) | Анхлан суралцагчаас 2 эхэн үе 3 |
| PA | | | | | Суургүй анхан шат (эхний цөөн сэдэвүүд) | Анхлан суралцагч 1 |

Happy Learning Академи нь суралцагчдыг зөвхөн хичээлдээ анхаарлаа төвлөрүүлээд зогсохгүй өөр өөр үндэстэнтэй харилцах замаар хэлийг бусадтай үр дүнтэй ашиглахад нь анхаардаг. Филиппин Улсын Себу хот дахь олон улсын хэлний сургууль гэдгээрээ бахархах нэг гол хүчин зүйл нь соёлын солилцоо юм.

# ХИЧЭЭЛИЙН **БҮТЭЦ**



## 04 - Ганцаарчилсан хичээл

Ганцаарчилсан хичээл нь багш нар сурагч бүрийн англи хэлний тодорхой ур чадвар тус бүр дээр тулж ажиллаж, мөн ерөнхий ур чадварын хичээлүүдээр сурагч бүрийн ахиц дэвшлийг нарийн тодорхойлоход тусладаг.
*Тодорхой ур чадвар – Сонсох, ярих, унших, бичих ур чадвар. *Ерөнхий ур чадвар – Нэг хичээлд 3-4 тодорхой ур чадваруудыг багтаасан анги.



## 03 - Групп / бүлгийн / хичээл

Багш ижил түвшний хэлний чадвартай групп (4-8) сурагчдад тодорхой ур чадварын болон ерөнхий ур чадварын хичээлийг хэлний практик хэрэглээнд тулгуурлан, харилцан ярилцаж, идэвхтэй суралцах арга барилд тулгуурлан бүлгийн хичээл явагддаг.



## 1 цагийн Спортын хичээл ба 1 цагийн Мультимедиа англи хэлний анги:

Спортын хичээл нь суралцагчдад хүнд хэцүү хичээлүүдийн дараа амрах, булчингаа хөгжүүлэх, сургуульд сурч буй суралцагчдад оюун ухаан, ур чадварын олон давуу талыг өгөх боломжийг олгодог. Хөгжмийн хичээл нь сурагчдад илүү их үгсийн сан олж авах, янз бүрийн дууны утгыг ойлгоход нь туслах зорилгоор сэтгэл хөдөлгөм сонирхолтой байдлаар зохион байгуулагддаг. ESL суралцагчдад зориулсан мультимедиа англи хэлний анги нь төрөл бүрийн дижитал нөөцөөр дамжуулан хэлний ур чадварыг дээшлүүлэхэд чиглэдэг. Сонсох, ярих, унших, бичих үйл ажиллагааг нэгтгэснээр сурагчид англи хэлтний утга учирыг ойлгон идэвхтэй хичээлд оролцдог. Энэ анги нь хэлийг үр дүнтэй эзэмшихэд дэмжлэг үзүүлэх интерактив, дэмжлэг үзүүлэх орчныг бүрдүүлэх зорилготой.



## 01 - Илтгэлийн сургалт ба Эссэ бичлэг

Суралцагчид илтгэлийн сургалтад 1 цаг, эссэ бичлэгт 1 цаг хамрагдана. Илтгэлийн сургалтад хамрагдсанаар сурагчид дуудлага илт сайжрахаас гадна өөртөө итгэлтэйгээр олны өмнө ярих чадвараа сайжруулж боломжтой. Харин тогтмол эссэ бичих нь тэдний үгсийн сан, өгүүлбэр зохиох, эссэ найруулах, зөв бичих чадварыг сайжруулдаг байна.

# ЕРӨНХИЙ ХУВААРЬ

## Өдөр тутмын хуваарь:

Хүүхэд бүр өөр өөр хуваарьтай байх бөгөөд бүх хүүхдүүдийг эцэг эхтэй нь холбогдсоны дагуу хичээл болон аялалд бүрэн хамруулах болно.

| PERIOD | TIME | CLASS TYPE | SUBJECT |
|---|---|---|---|
| | 7:45 - 8:05 | Vocabulary Test | |
| 1st | 8:10 - 9:00 | One to One | Reading |
| 2nd | 9:05 - 9:55 | Group Class | Listening |
| 3rd | 10:05 - 10:55 | One to One | Speaking |
| 4th | 11:00 - 11:50 | Group Class | Writing |
| | 11:50 - 13:00 | Lunch time | |
| 5th | 13:00 - 13:50 | One to One | Vocabulary |
| 6th | 13:55 - 14:45 | Group Class | Sports Class |
| 7th | 14:50 - 15:40 | One to One | Grammar |
| 8th | 15:45 - 16:35 | Optional Class | Music \| Multimedia English Class |
| 9th | 16:40 - 17:30 | Group Class | General Skills |
| | 17:55 - 19:00 | Dinner and Break time | |
| Night class | 19:00 - 20:00<br>20:00 - 21:00 | Speech Training and Essay Writing sessions are offered from Sunday to Thursday | |
| Roll call | 22:00 ( Sunday to Thursday )<br>23:00 ( Friday and Saturday ) | | Personal Hygiene<br>Sleeping Time |

▪ Ярианы сургалт болон эссэ бичих хичээлээ дуусгасан сурагчид сургуулийн талбайд үйл ажиллагаанд чөлөөтэй оролцож болно.



Ганцаарчилсан хичээл



Групп хичээл

# HLA CAMP IELTS

Энэ шалгалт нь ихэвчлэн **IELTS (Олон улсын англи хэлний шалгалтын систем)** шалгалтанд хүссэн оноогоо авахад нь туслах зорилготой тусгай бэлтгэлийн хөтөлбөр юм. Хөтөлбөрууд нь ихэвчлэн лекц, бэлтгэлийн шалгалтыг багтаасан эрчимтэй, төвлөрсөн бэлтгэлийг богино хугацаанд хангахаар бүтэцтэй байдаг. Зорилго нь суралцагчийн IELTS-ийн шалгалтанд өөртөө итгэх итгэл, гүйцэтгэлийг нэмэгдүүлж, академик болон цагаачлалын зорилгоор шаардлагатай оноог авахад нь туслах явдал юм.

## IELTS ангийн бүтэц:

### 05 – 1:1 ангиуд

Манай IELTS-ийн 1:1 ангийн зорилго нь сурагч бүрийн өвөрмөц хэрэгцээ, зорилгод тохирсон хувь хүний онцлогт тохирсон сургалтыг өгөх явдал юм. Бид IELTS-ийн шалгалтын Сонсох, Унших, Бичих, Ярих гэсэн дөрвөн хэсгийн чадварыг сайжруулахын тулд тохирсон хичээлүүд, зорилтот дадлагыг санал болгодог. Манай анги нь сурагчдыг тестийн форматтай сайтар танилцаж, хэсэг тус бүрийн хэсэгт үр дүнтэй стратеги боловсруулахад зориулагдсан. Хувь хүнд чиглэсэн санал хүсэлт, дэмжлэгтэйгээр бид сурагчдын давуу тал болон сайжруулах шаардлагатай талбаруудыг тодорхойлж итгэлцэл, гүйцэтгэлийгсаижруулдаг. Бидний гол зорилго бол сурагч бүрийг хүссэн IELTS оноогоо авч, академик болон цагаачлалын хүсэл зорилгодоо амжилттай хүрэхэд нь туслах явдал юм.

### 02 бүлгийн ангиуд

IELTS-ийн бүлгийн ангийн зорилго нь сурагчдыг IELTS-ийн шалгалтанд өндөр оноо авахад шаардлагатай ур чадвар, мэдлэгээр хангах явдал юм. Бид зорилтот хичээл, дадлагаар дамжуулан Сонсох, Унших, Бичих, Ярих чадварыг цогцоор нь хөгжүүлэхэд анхаардаг. Тус анги нь сурагчдыг тестийн хэлбэр, янз бүрийн асуултуудыг шийдвэрлэх үр дүнтэй стратегитай танилцуулахыг зорьдог. Сургагчид байнгын санал хүсэлт, интерактив сургалтын боломжоор хангаснаар сурагчдыг өөртөө итгэх итгэлийг бий болгож, бие даан сорилтуудыг шийдвэрлэхэд тусалдаг. Эцсийн гол зорилго нь сурагч бүр хүссэн IELTS оноогоо авч, академик болон цагаачлалын зорилгодоо сайн бэлтгэгдсэн байх явдал юм.




### 1 цагийн Спортын хичээл ба 1 цагийн Мультимедиа англи хэлний анги:

Спортын хичээл нь сурагчдыг хүнд хичээлийн дараа тайвшрах, амрах булчингаа хөгжүүлэх, сурагчдад оюун ухаан, ур чадварын олон давуу талыг олох боломжийг олгодог. Хөгжмийн хичээл нь сурагчдад үгсийн сан нэмэгдүүлэх, янз бүрийн дууны утгыг ойлгоход нь туслах зорилготой сэтгэл хөдөлгөм сонирхолтой байдлаар зохион байгуулагддаг. ESL суралцагчдад зориулсан мультимедиа англи хэлний анги нь төрөл бүрийн дижитал эх сурвалжаар дамжуулан хэлний ур чадварыг дээшлүүлэхэд чиглэдэг. Сонсох, ярих, унших, бичих үйл ажиллагааг нэгтгэснээр сурагчид хэлийг ойлгож хэл сурч буй орчинг улам бүрдүүлж өгдөг. Энэ анги нь хэлийг үр дүнтэй эзэмшихэд дэмжлэг үзүүлэх зорилготой.

### 01 - Илтгэлийн сургалт ба Эссэ бичлэг

Суралцагчид илтгэлийн сургалтад 1 цаг, эссэ бичлэгт 1 цаг хамрагдана. Илтгэлийн сургалтад хамрагдсанаар сурагчид дуудлага илт сайжрахаас гадна өөртөө итгэлтэйгээр олны өмнө ярих чадвараа сайжруулж боломжтой. Харин тогтмол эссэ бичих нь тэдний үгсийн сан, өгүүлбэр зохиох, эссэ найруулах, зөв бичих чадварыг сайжруулдаг байна.



# IELTS АНГИЙН БҮТЭЦ

| PERIOD | TIME | CLASS TYPE | SUBJECT |
|---|---|---|---|
| | 7:45 - 8:05 | Vocabulary Test | |
| 1st | 8:10 - 9:00 | One to One | IELTS Reading |
| 2nd | 9:05 - 9:55 | One to One | IELTS Listening |
| 3rd | 10:05 - 10:55 | One to One | IELTS Speaking |
| 4th | 11:00 - 11:50 | Group Class | General Skills |
| | 11:50 - 13:00 | Lunch time | |
| 5th | 13:00 - 13:50 | One to One | IELTS Writing |
| 6th | 13:55 - 14:45 | One to One | IELTS Grammar |
| 7th | 14:50 - 15:40 | Group Class | Sport Class |
| 8th | 15:45 - 16:35 | Group Class | IELTS Vocabulary |
| 9th | 16:40 - 17:30 | Optional Class | Music \| Multimedia English Class |
| | 17:55 - 19:00 | Dinner and Break time | |
| Night class | 19:00 - 20:00<br>20:00 - 21:00 | Speech Training and Essay Writing sessions are offered from Sunday to Thursday | |
| Roll call | 22:00 ( Sunday to Thursday )<br>23:00 ( Friday and Saturday ) | | Personal Hygiene<br>Sleeping Time |

# IELTS ҮР ДҮН







IELTS-ийн сургалт нь сурагчдад Сонсох, Ярих, Унших, Бичих чадвараа сайжруулах, IELTS-ийн шалгалтын бодит форматтай танилцах, мөн оноогоо хялбархан нэмэгдүүлэхэд тусалдаг.

HLA-д суралцаж буй сурагчид бүгд 8 долоо хоногийн курсээр оноогоо 4.0-6.0, 20 долоо хоногийн хугацаанд 1.0-ээс 5.0 хүртэл оноогоо ахиулж чадна. Энэхүү амжилт нь HLA-ийн туршлагатай багш нарын үр дүнтэй заах арга барил, сурагчдын тасралтгүй шаргуу хөдөлмөр, хичээл зүтгэлийн үр дүн юм.

# ДОЛОО ХОНОГИЙН ХУВААРЬ

Хөтөлбөрийн долоо хоногийн хуваарийг доорх жишээ хуваарьт үзүүлэв.

<table>
<tr><th rowspan="2">ХИЧЭЭЛ</th><th rowspan="2">ЦАГ</th><th>ХУГАЦАА</th><th colspan="2">ҮЙЛ АЖИЛЛАГАА</th></tr>
<tr><th>ДАВАА-БААСАН</th><th>БЯМБА</th><th>НЯМ</th></tr>
<tr><td>...</td><td>07:00 - 07:30</td><td>Сэрэх | Өглөөний дасгал</td><td rowspan="14">Себу дэх алдаратай газруудаар аялах:<br>· Jpark Island<br>· Solea Resort<br>· Danasan<br>· Island Hopping<br>· City Tour<br>· Cebu Safari<br>· Ocean Park<br>· Plantation Bay<br>· Water sports<br>· Anjo World<br>· Water World</td><td rowspan="14">· Спорт тэмцээнүүд<br>(Сагсан бөмбөг, усанд сэлэлт, ширээний теннис, гольф, зумба гэх мэт.)<br>· Уламжлалт тоглоом<br>· Spelling Bee<br>· Golden Bell<br>· Эрүүл мэндийн үзлэг<br>· Бие даан суралцах<br>· Дэлгүүр явах</td></tr>
<tr><td>...</td><td>07:30 - 07:45</td><td>Өглөөний цай</td></tr>
<tr><td>...</td><td>07:45 - 08:05</td><td>Өдөр тутмын шинэ үгийн шалгалт</td></tr>
<tr><td>1st</td><td>08:10 - 09:00</td><td>Ярианы хичээл</td></tr>
<tr><td>2nd</td><td>09:05 - 09:55</td><td>Дүрмийн хичээл</td></tr>
<tr><td>3rd</td><td>10:05 - 10:55</td><td>Спорт хичээлүүд</td></tr>
<tr><td>4th</td><td>11:00 - 11:50</td><td>Сонсголын хичээл</td></tr>
<tr><td>...</td><td>11:50 - 13:00</td><td>Үдийн хоол</td></tr>
<tr><td>5th</td><td>13:00 - 13:50</td><td>Уншлагын хичээл</td></tr>
<tr><td>6th</td><td>13:55 - 14:45</td><td>Дуудлагын хичээл</td></tr>
<tr><td>7th</td><td>14:50 - 15:40</td><td>Эмповер</td></tr>
<tr><td>8th</td><td>15:45 - 16:35</td><td>Бичих ур чадварын хичээл</td></tr>
<tr><td>9th</td><td>16:40 - 17:30</td><td>Поп дуу</td></tr>
<tr><td>...</td><td>17:55 - 19:00</td><td>Оройн хоол</td></tr>
<tr><td>Оройн анги</td><td>19:00 - 20:00</td><td>Илтгэх сургалт /Олон нийтийн өмнө ярих дадлага</td><td colspan="2" rowspan="2">Долоо хоног бүрийн ням гарагаас пүрэв гараг хүртэл Илтгэлийн сургалт, Эссэ бичих хичээлүүдийг явуулдаг.</td></tr>
<tr><td>Оройн анги</td><td>20:00 - 21:00</td><td>Эссэ бичлэг</td></tr>
<tr><td colspan="3">22:00 (бүтэнсайн өдрөөс пүрэв гараг хүртэл)<br>23:00 (Баасан гараг болон Хагассайнд)</td><td colspan="2">Хувийн цаг |<br>Сурагчдын бүртгэл болон унтлагын цаг</td></tr>
</table>

**Жич:**

- Бямба гарагийн үйл ажиллагааны талаар сурагч, асран хамгаалагч багшид урьдчилан мэдэгдэнэ.
- Цаг агаарын нөхцөл байдал, сурагчдын эрүүл мэндээс шалтгаалж үйл ажиллагааг оновчтой зохион байгуулна.
- Бямба гарагийн 19:00 цагаас Ням гарагийн 19:00 цаг хүртэл гар утсыг сурагчдад өгч, ашиглуулах боломжтой.

# САР БҮРИЙН
# ҮЙЛ АЖИЛЛАГАА

## 1-р долоо хоног

**Ням** — Сургуульд ирэх



**Даваа** — Элсэлтийн шалгалт, кампустай танилцах, чиг баримжаа олгох хичээл



**Мягмар** — Угталтын үдэшлэг




**Лхагва** — Ганцаарчилсан хичээл



**Пүрэв** — Усан сэлэлтийн хичээл



**Баасан** — Групп хичээл



**Бямба** — Усан спорт



## 2-р долоо хоног

**Ням** — Спортын тэмцээн



**Даваа** — Ганцаарчилсан хичээл



**Мягмар** — Групп хичээл



**Лхагва** — Ширээний теннис



**Пүрэв** — Зумба



**Баасан** — Групп хичээл



**Бямба** — Cebu Safari



## 3-р долоо хоног

**Ням** — Эрүүл мэндийн үзлэг



**Даваа** — Ганцаарчилсан хичээл



**Мягмар** — Групп хичээл



**Лхагва** — Хөгжмийн хичээл



**Пүрэв** — Спортын хичээл



**Баасан** — Групп хичээл



**Бямба** — Арлын аялал



## 4-р долоо хоног

**Ням** — Дэлгүүр явах



**Даваа** — Илтгэх дадлага



**Мягмар** — Групп хичээл



**Лхагва** — Гарах тест



**Пүрэв** — Групп хичээл



**Баасан** — Төгсөлт



